



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 6 (531)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*
- *Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*
- *Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2008 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2008 оны хоёрдугаар сарын 14

№6 (531)

Гарчиг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

| | | |
|------|--|-----|
| 85. | Татварын зарим хууль болон нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх тухай | 101 |
| 86. | Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 103 |
| 87. | Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 106 |
| 88. | Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 107 |
| 89. | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 109 |
| 90. | Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 110 |
| 91. | Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд нэмэлт оруулах тухай | 111 |
| 92. | Эх, хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд, эх, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 111 |
| 93. | Худалдааны хэлэлцээр соёрхон батлах тухай | 112 |
| 94. | Монгол Улсын Засгийн газар, олон улсын хөгжлийн ассоциаци хооронд байгуулсан "Тогтвортой амжиргаа-2" төслийн санхүүжилтийн гэрээг соёрхон батлах тухай | 112 |
| 95. | Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 112 |
| 96. | Ойн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 116 |
| 97. | Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 117 |
| 98. | Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 117 |
| 99. | Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай | 127 |
| 100. | Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 127 |
| 101. | Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 128 |
| 102. | Дүрэм соёрхон батлах тухай | 128 |
| 103. | Хэлэлцээр соёрхон батлах тухай | 128 |

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2007 оны 12 дугаар сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

ТАТВАРЫН ЗАРИМ ХУУЛЬ БОЛОН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Хувь хүний орлогын албан татварын тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, Онцгой албан

татварын тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай, Нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан иргэн, хуулийн этгээд сайн дурын үндсэн дээр татвар төлөгчөөр



бүртгүүлсэн буюу албан татвар ногдох орлого болон орлогоос бусад албан татвар ногдох бараа, ажил, үйлчилгээ, үйл ажиллагааг мэдүүлсэн тохиолдолд тэдгээрийг хариуцлага болон албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлээс нэг удаа чөлөөлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

2.1.Татварын ерөнхий хууль, тухайн төрлийн татварын хууль болон Нийгмийн даатгалын тухай хуульд албан татвар төлөгч болон ажил олгогч байхаар тодорхойлогдсон иргэн, хуулийн этгээдэд энэ хууль үйлчилнэ.

3 дугаар зүйл. Албан татвар төлөгч, ажил олгогчоор бүртгүүлэх

3.1.Энэ хуулийн 2.1-д заасан хуулийн дагуу 2008 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнөх хугацаанд албан татвар төлөгч, ажил олгогчоор бүртгүүлсэн бйвал зохих иргэн, хуулийн этгээд ийнхүү бүртгүүлээгүй боловч энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 6 сарын дотор харьяалах татварын алба, нийгмийн даатгалын орон нутгийн салбар нэгжид сайн дурын үндсэн дээр бүртгүүлсэн бол дор дурдсан хуульд заасан хариуцлагаас чөлөөлнө:

3.1.1.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17.1;

3.1.2.Татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах тухай хуулийн 42.1.1;

3.1.3.Захиргааны хариуцлагын тухай хуулийн 44 дүгээр зүйл;

3.1.4.Эрүүгийн хуулийн 167 дугаар зүйл;

3.1.5.Нийгмийн даатгалын тухай хуулийн 20.1.1.

3.2.Энэ хуулийн 3.1-д заасны дагуу албан татвар төлөгч, ажил олгогчоор бүртгүүлсэн иргэн, хуулийн этгээдийн ийнхүү бүртгүүлэхээс өмнөх хугацаанд олсон албан татвар ногдох орлого болон орлогоос бусад албан татвар ногдох бараа, ажил, үйлчилгээ, үйл ажиллагаа /цаашид" орлогоос бусад албан татвар ногдох зүйл" гэх/-нд албан татвар, хүү,

торгууль, түүнчлэн нийгмийн даатгалын шимтгэл нөхөн ногдуулахгүй.

3.3.Энэ хуулийн 3.1-д заасны дагуу албан татвар төлөгчөөр бүртгүүлэхэд Татварын ерөнхий хууль, Татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах тухай хууль болон тухайн төрлийн татварын хуульд заасан журмыг баримтална.

4 дүгээр зүйл. Албан татвар ногдох орлого, орлогоос бусад албан татвар ногдох зүйлийг мэдүүлэх, нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогыг зөв тайлагнах

4.1.Энэ хуулийн 2.1-д заасан хуульд заасны дагуу 2008 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнөх хугацаанд олсон албан татвар ногдох орлого, орлогоос бусад албан татвар ногдох зүйл, түүнчлэн нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогыг нуун дарагдуулсан боловч энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 6 сарын дотор санхүүгийн болон албан татварын, нийгмийн даатгалын шимтгэлийн шинэчилсэн тайланг гаргаж харьяалах татварын алба, нийгмийн даатгалын орон нутгийн салбар нэгжид сайн дурын үндсэн дээр мэдүүлсэн бол тухайн иргэн, хуулийн этгээдийг дор дурдсан хуульд заасан хариуцлагаас чөлөөлнө:

4.1.1.Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-3 дахь заалт;

4.1.2.Татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах тухай хуулийн 42 дугаар зүйл;

4.1.3.Захиргааны хариуцлагын тухай хуулийн 44 дүгээр зүйл;

4.1.4.Эрүүгийн хуулийн 166,167 дугаар зүйл;

4.1.5.Нийгмийн даатгалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг.

4.2.Энэ хуулийн 4.1-д заасны дагуу харьяалах татварын албанд гаргаж өгсөн санхүүгийн болон албан татварын шинэчилсэн тайланг эхлэлтийн тайлан, баланс, нийгмийн даатгалын орон нутгийн салбар нэгжид ажил олгогчийн гаргаж өгсөн нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг эхлэлтийн тайлан гэж тус тус үзэх бөгөөд эдгээр тайланд мөн хуульд заасны дагуу сайн дурын үндсэн дээр мэдүүлж шинээр



тусгасан албан татвар ногдох орлого, орлогоос бусад албан татвар ногдох зүйлд албан татвар, хүү, торгууль, түүнчлэн нийгмийн даатгалын шимтгэл нөхөн ногдуулахгүй.

4.3. Энэ хуулийн 4.1-д заасны дагуу чөлөөлөгдөх албан татвар, шимтгэлд дор дурдсан албан татвар, шимтгэл хамаарна:

4.3.1. хувь хүний орлогын албан татвар;

4.3.2. аж ахуйн нэгжийн орлогын албан татвар;

4.3.3. орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татвар;

4.3.4. нэмэгдсэн өртгийн албан татвар;

4.3.5. гаалийн албан татвар;

4.3.6. онцгой албан татвар;

4.3.7. автобензин, дизелийн түлшний албан татвар;

4.3.8. бууны албан татвар;

4.3.9. үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар;

4.3.10. авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар;

4.3.11. нийгмийн даатгалын шимтгэл.

4.4. Энэ хуулийн 4.1-4.3-т зааснаас бусад албан татвар ногдох орлого, орлогоос бусад албан

татвар ногдох зүйлийг албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөхгүй.

4.5. 2008 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хойш албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу гаргасан шинэчилсэн тайланг үргэлжлүүлэн хөтөлсөн санхүүгийн болон албан татварын, нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд үндэслэн ногдуулна.

5 дугаар зүйл. Өршөөл үзүүлэх

5.1. 2008 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө Эрүүгийн хуулийн 166, 167 дугаар зүйлд заасан гэмт хэрэг үйлдсэн этгээдэд өршөөл үзүүлэх асуудлыг тусгай хуулиар зохицуулна.

6 дугаар зүйл. Бусад зүйл

6.1. Энэ хуулийн 3.1, 4.1-д заасны дагуу эрүүгийн болон захиргааны хариуцлагаас чөлөөлөгдөх иргэн, хуулийн этгээдэд эрүүгийн хэрэг үүсгэх, захиргааны хариуцлага хүлээлгэх, гүйцэтгэх ажил явуулахыг хориглоно.

6.2. Энэ хуулийн 6.1-д заасан иргэн, хуулийн этгээдэд холбогдох мэдээлэл, тэдний мэдүүлсэн албан татварын, нийгмийн даатгалын шимтгэлийн шинэчилсэн тайлан, эдгээр тайланд тусгагдсан албан татвар ногдох орлого, орлогоос бусад албан татвар ногдох зүйл, шимтгэл ногдох орлогын эх үүсвэр, хэмжээ, үнэ, өртгийг нууцлах бөгөөд нотлох баримт болгон ашиглахыг хориглоно.

7 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

7.1. Энэ хуулийг 2008 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийгмийн халамжийн тухай хуульд дор дурдсан агуулгатай зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/ 19¹ дүгээр зүйл:

19¹ дүгээр зүйл. Нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмж авах эрх
19¹. Дор дурдсан иргэн нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмж авах эрхтэй:

19¹.1.1. Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж, харгалзан дэмжиж байгаа;

19¹.1.2. Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас сэтгэл санааны болон бие мах бодийн хохирол хүлээж хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг Гэр бүлийн тухай хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу гэр бүлдээ авч асрамжилж байгаа;

19¹.1.3. Тэжээн тэтгэх хүүхэдгүй, төрөл, садангийн хүнгүй, ганц бие ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй ганц бие иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа;

19¹.1.4. Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асарч байгаагийн улмаас хөдөлмөр эрхлэдэггүй хөдөлмөрийн насны.

19¹.2. Энэ хуулийн 19¹.1-д заасан иргэнийг асаргаа, сувилгааны болон гэр бүлдээ авч асрамжлах үйлчилгээний ур чадвар эзэмшүүлэх сургалтад хамруулна. Сургалтыг олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний зардлаас санхүүжүүлнэ.

19¹.3. Энэ хуулийн 19¹.2-т заасан сургалтыг зохион байгуулах журам болон сургалтын хөтөлбөрийг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална."

2/6 дугаар зүйлийн 5, 8, 9, 10 дахь хэсэг:

"6.5. Нийгмийн ажилтны ажлын ачааллын жишиг нормативыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

6.8. Нийгмийн халамжийн мэргэжлийн хяналтыг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9.1-д заасан байгууллага хэрэгжүүлнэ.

6.9. Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь нийгмийн халамж үйлчилгээний анхан, дунд шатны байгууллагын үйл ажиллагааны талаар мэргэжлийн зөвлөгөө өгөх, нөхцөлт мөнгөн тэтгэмж, хөндсөн тусламж болон нийгмийн халамжийн зориулалттай хөрөнгийн, эзэлийн, хандивын зарцуулалтад хяналт тавих, хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хариуцлага ногдуулах саналаа энэ хуулийн 6.8-д заасан байгууллагад тавих чиг үүрэг бүхий хяналт, шинжилгээ, үнэлгээний нэгжтэй байж болно.

6.10. Аймаг, дүүргийн нийгмийн халамж үйлчилгээний байгууллага хяналт, шинжилгээ,

үнэлгээний асуудал хариуцсан ажилтантай байж болно."

3/9 дүгээр зүйлийн 2, 3, 6, 7, 8, 9 дахь

хэсэг:

"9.2. Энэ хуулийн 3.1.2-т зааснаас бусад иргэнд нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай эсэхийг амьжиргааны түвшинг нь харгалзан Зөвлөл тогтооно. Амьжиргааны түвшин тогтоох аргачлалыг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Үндэсний статистикийн хороо хамтран батална.

9.3. 2000-аас дээш хүн амтай баг, тосгонд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр Зөвлөл ажиллуулж болно.

9.6. Зөвлөлийн шийдвэр нь олон нийтэд нээлттэй, ил тод байна.

9.7. Зөвлөлийн үйл ажиллагаатай холбогдох зайлшгүй зардлыг халамжийн сангаас санхүүжүүлнэ.

9.8. Зөвлөлийн гишүүнд болон сум, хорооны нийгмийн ажилтанд ажлын оролцоо, идэвх чармайлтыг харгалзан улиралд нэг удаа урамшуулал олгож болно. Урамшууллын хэмжээ, олгох журмыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

9.9. Энэ хуулийн 9.8-д заасан зардлыг нийгмийн халамжийн сангаас санхүүжүүлнэ."

4/10 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

"10.5. Нийгмийн ажилтан Төрийн албаны тухай хуулийн 27.1-д заасан баталгаанаас гадна дор дурдсан нөхцөл, баталгаагаар хангагдана:

10.5.1. ажлын онцлогоос шалтгаалан тусгай өрөө, эсхүл тусгаарлалт бүхий ажлын байр болон шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангагдах;

10.5.2. сум, хороонд 25 ба түүнээс дээш жил ажилласан нийгмийн ажилтан өндөр насны тэтгэвэр тогтоолох бол 12 сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тусламжийг ажиллаж байгаа байгууллагаасаа авах."

5/13 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 6 дахь заалт:

"13.2.6. Зөвлөлийн гишүүн, сум, хорооны нийгмийн ажилтанд олгох урамшил болон халамжийн үйл ажиллагааны зардал."

6/17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт:



"17.1.4. тэжээгч нь нас барсан гэр бүлийн 18 хүртэлх насны хүүхдийн халамжийн тэтгэвэр."

7/ 18 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт:

"18.1.6. тэжээгч нь нас барсан гэр бүлийн 18 хүртэлх насны хүүхэд."

8/ 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 5, 6, 7 дахь заалт:

"19.1.5. бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж, харгалзан дэмжиж байгаа иргэнд олгох тэтгэмж;

19.1.6. Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас сэтгэл санааны болон бие мах бодийн хохирол хүлээж хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж;

19.1.7. ганц бие ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй ганц бие иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж."

9/ 25 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"25.2. Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламжийг дор дурдсан өрх, иргэнд олгоно:

25.2.1. гурав хүртэлх насны ихэр хүүхдэд жилд нэг удаа;

25.2.2. байнгын асаргаа шаардлагатай иргэнд улиралд нэг удаа;

25.2.3. гурав ба түүнээс дээш тооны бага насны хүүхэдтэй /14 хүртэлх насны/ өрх толгойлсон эх /эцэг/-д жилд нэг удаа;

25.2.4. 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэнд болон гэнэтийн аюул, ослын улмаас гэр оронгүй болсон өрхөд гэр авахад нь дэмжлэг үзүүлж нэг удаа."

10/ 28 дугаар зүйлийн 1 хэсгийн 4 дэх заалт:

"28.1.4. гурав ба түүнээс дээш ихэр хүүхдийн асрамжийн."

11/ 28 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалт:

"28.2.4. гурав ба түүнээс дээш ихэр хүүхэд."

12/ 28 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

"28.3. Гурав ба түүнээс дээш ихэр хүүхдийг 4 нас хүртэл нь төрийн зардлаар асрамжилна."

13/ 30 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

"30.3. Төрөлжсөн асрамжийн газарт, асуулагчийг хүлээн авах, шилжүүлэх, гаргах, асрамжийн газрыг магадлан итгэмжлэх болон асрамжийн газрын төсвийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журмыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална."

2 дугаар зүйл. Нийгмийн халамжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн гарчигийн "тогтолцоо" гэсний дараа "хяналт", 9.4-ийн "дүрмийг" гэсний өмнө "ажиллах", 10.3.2-ын "тусламж" гэсний өмнө "амьжиргаанд дэмжлэг үзүүлэх", 13.2.5-ын "ганц бие" гэсний дараа "хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон ганц бие", 15.2-ын "байгууллага" гэсний өмнө "төв", 18.1.3-ын "одой" гэсний өмнө "16 насанд хүрсэн", 26.3-ын "хөгжлийн бэрхшээлтэй" гэсний дараа "хүүхэд ба", 27.1-ийн "үйлчилгээ" гэсний өмнө "тадгээрийг олгох журам, 26 дугаар зүйлд заасан", 31.4-ийн "иргэний" гэсний өмнө "амьжиргаанд дэмжлэг үзүүлэх хөнгөлөлт, тусламжид хамрагдах", 35.1-ийн "тогтоолгосон," гэсний дараа "амьжиргаанд дэмжлэг үзүүлэх хөнгөлөлт, тусламж," гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Нийгмийн халамжийн тухай хуулийн дараахь зүйлийн хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 3, 7, 8 дахь заалт:

"3.1.1. нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа шаардлагатай хүнд энэ хуульд заасан тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг "нийгмийн халамж" гэнэ;

3.1.2. байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хүнд нөхцөлд байгаа хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй, түүнчлэн 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн, олон хүүхэдтэй, өрх толгойлсон эх /эцэг/-ийг "нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа шаардлагатай хүн" гэнэ;

3.1.3. бусдын тусалцаагүйгээр өдөр тутмын үйлдлээ бие даан гүйцэтгэх чадваргүй, бусдын асрамжид байнга байгаа хүнийг "байнгын асаргаа шаардлагатай иргэн" гэнэ;

3.1.7. байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, бүтэн өнчин, Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас сэтгэл санааны, бие махбодийн хохирол хүлээж хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг асрамжилж байгаа иргэнд тодорхой шалгуур, болзолтой олгох мөнгөн тусламжийг "нөхцөлт мөнгөн тэтгэмж" гэнэ;



3.1.8. иргэн, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн оролцоотойгоор энэ хуулийн 3.1.2, 3.1.3-т заасан хүнд үзүүлж буй дэмжин туслах үйлчилгээг "олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ" гэнэ."

2/8 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

"8.4. Энэ хуулийн 8.3-т заасан иргэн, байгууллагыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага бүртгэж, гэрчилгээ олгоно. Тэдгээрийн нийгмийн халамж, асрамжийн үйл ажиллагааны зардлыг орон нутгийн төсөв, халамжийн сангаас гэрээний үндсэн дээр хэсэгчлэн буоу бүрэн санхүүжүүлж болно."

3/9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

"9.1. Энэ хуулийн 3.1.2-т заасан хүнийг нийгмийн халамжид хамруулахаар тодорхойлох, шийдвэр гаргах үүрэг бүхий Амьжиргааг дэмжих орон тооны бус зөвлөл /цаашид "Зөвлөл" гэх/ сум, хороонд ажиллана."

4/18 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт:

"18.1.4. хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 16 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн;"

5/25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт:

"25.1.2. орон сууцны хөлсний болон түлшний үнийн хөнгөлөлт;"

6/26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

"26.1. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай өрх, иргэнд үзүүлэх олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ дараахь төрөлтэй байна."

7/26 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 5 дахь заалт:

"26.2.5. байнгын асаргаа шаардлагатай иргэн 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин

болсон 18-24 насны иргэн, 3 ба түүнээс дээш тооны бага насны /14 хүртэлх насны/ хүүхэдтэй өрх толгойлсон эх /эцэг/."

4 дүгээр зүйл. Нийгмийн халамжийн тухай хуулийн 10.3.1-ийн "нийгмийн эмзэг бүлгийн болон ядуу өрх," гэснийг "нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай өрх", 13.2.2-ын "нийгмийн эмзэг бүлгийн" гэснийг "нийгмийн халамжийн туслалцаа шаардлагатай өрх, иргэний", 16.1 дэх хэсгийн "бүртгэл" гэснийг "мэдээ", 18.1.1-ийн "садангүй" гэснийг "садангийн хүнгүй", 25 дугаар зүйлийн гарчгийг "Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай өрх, иргэнд үзүүлэх хөнгөлөлт, тусламжийн бүлэгт хамрагдсан өрх иргэнд үзүүлэх" гэснийг "Энэ хуулийн 25 дугаар зүйлд заасан", 24.1, 34.1-ийн "Улсын Их Хурал" гэснийг "Засгийн газар", 31.4-ийн "жагсаалтыг" гэснийг "жагсаалт, дэвтэр, маягтын загварыг", 6.5, 6.6 дахь хэсгийн дугаарыг "6.6", "6.7", 9 дүгээр зүйлийн 9.2, 9.3 дахь хэсгийн дугаарыг "9.4", "9.5", 9 дүгээр зүйлийн "9.4" дэх хэсгийн дугаарыг "9.10" гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Нийгмийн халамжийн тухай хуулийн 10.3.3-аас "нийгмийн эмзэг бүлгийн", 10.3.4-ээс "нийгмийн эмзэг бүлэг, ядуу, нэн ядуу өрх", 13.2.5-ын "нэн ядуу", 18.1.1, 18.1.2, 18.1.5-аас "нэн ядуу амьдралтай", 18.1.3-аас "бүрэн хараагүй, хэлгүй, дүлий", 26.2-оос "ядуу, нэн ядуу амьдралтай", 26.2.2-оос "хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан", 26.3-аас "хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан", "25.1.1-д заасан тусламжид халамжийн тэтгэвэр, тэтгэмж нь зогсоогдсон эмзэг бүлгийн иргэн" гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл. Нийгмийн халамжийн тухай хуулийн 21, 22 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

АХМАД НАСТНЫ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 5, 8 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалт:

" 5.1.8. нийслэлээс 1000 ба түүнээс дээш км алслагдсан газарт байнга оршин суудаг ахмад настан аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын хяналтын комиссын шийдвэрээр нийслэлд ирж эмчлүүлэх, шинжилгээ хийлгэх тохиолдолд



унааны нэг талын зардлыг жилд нэг удаа нөхөн олгох;

2/ 5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

"5.3.Энэ хуулийн 5.1.3-т заасан хөнгөлөлт, тусламжид хамрагдах ахмад настныг тухайн орон нутгийн ахмадын байгууллагын саналыг харгалзан Амьжиргааг дэмжих зөвлөл тодорхойлж, шийдвэрлэнэ.

3/ 8 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:

"8.6. Энэ хуулийн 8.5-д заасан "Ахмадын сан" байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална."

2 дугаар зүйл. Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 5.1.1-ийн "ортопедийн хэрэгсэл" гэсний дараа "худалдан авсан болон", 5.1.4-ийн "ахмад настан" гэсний өмнө "ахмад настан болон эмчилгээ, сувилгаа зайлшгүй шаардлагатай", мөн заалтын "дотоодын" гэсний өмнө "магадлан итгэмжлэгдсэн" гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн дараахь хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, мөн хэсгийн 10 дахь заалтын 3 дахь дэд заалт:

" 5.1.3. тэжээн тэтгэх хүүхэдгүй, эсхүл хууль ёсны тэжээн тэтгэгч нь дэмжлэг туслагдаа үзүүлэх боломжгүй нь тогтоогдсон ахмад настанд болон хүндэт донор ахмад настанд орон сууцны хөлс төлөхөд, хэрэе нийтийн халаалтгүй сууц, гэрт

амьдардаг бол түлш худалдан авахад нь жилд нэг удаа мөнгөн тусламж олгох;

5.1.10.3. орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлш худалдан авахад нь жилд нэг удаа мөнгөн тусламж олгох;"

2/ 8 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

"8.5.Энэ хуулийн 8.4-т заасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд зориулан төсөвт байгууллага үйл ажиллагааны зардлын хэмнэлтээс, аж ахуйн нэгж, байгууллага үлдэгдэл ашгаас цалингийн нийт сангийн 3 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулна."

4 дүгээр зүйл. Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 5.1.1-ийн "хийлгэх нэг удаагийн зардал" гэснийг "хийлгэсэн зардлын үнийг 5 жил тутам нэг удаа нөхөн", мөн зүйлийн 5.1.6-ийн "Авто тээврийн тухай хуулийн 12.2-т заасны дагуу үнэ төлбөргүй буюу хөнгөлөлттэй үнээр" гэснийг "орон нутгийн харьяалал харгалзахгүй үнэ төлбөргүй", 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8, 9, 10 дахь заалтын дугаарыг "9.", "10.", "11.", "5.1.10.1.", "5.1.10.2.", "5.1.10.3." гэсэн дэд заалтуудын дугаарыг "5.1.11.а.", "5.1.11.б.", "5.1.11.в.", 8 дугаар зүйлийн "6" дахь хэсгийн дугаарыг "7" гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 5.1.4-ийн "нэн ядуу амьдралтай, түүнчлэн", 5.1.5-ын "нэн ядуу" гэснийг тус тус хассугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 5, 8, 9, 10 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/ 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5.1.9-5.1.13 дахь заалт:

"5.1.9. нийслэлээс 1000 ба түүнээс дээш км алслагдсан газарт байнга оршин суудаг хөгжлийн бэрхшээлтэй хүн аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын хяналтын комиссын шийдвэрээр нийслэлд ирж эмчлүүлэх,

шинжилгээ хийлгэх тохиолдолд нэг талын унааны зардлыг жилд нэг удаа нөхөн олгох;

5.1.10. хараагүй хүний брайлын үсгээр бичсэн захидал, ил захидал, брайль хэвлэл 10 кг хүртэлх илгээмжийг дотоодод үнэ төлбөргүй явуулж, хараагүй хүний зориулалттай техник, тоног төхөөрөмж, материал хэрэгслийг дотоодод үнэ төлбөргүй хүргүүлэх;

5.1.11. бүрэн хараагүй хүн эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр эмчлүүлэх, рашаан сувилалд сувилуулахаар аймгаас



нийслэлд, нийслэлээс аймагт зорчих шаардлагатай болвол ирж буцах унааны зардлын 75 хувийг жилд нэг удаа нөхөн олгох;

5.1.12. хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нь хүүхдийн зусланд амарвал эрхийн бичгийн үнийн 50 хувийг жилд нэг удаа олгох;

5.1.13. нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасан оршуулгын тэтгэмж авах эрх үзэсгээг, хөгжлийн бэрхшээлтэй ганц бие иргэн нас барвал түүний оршуулгын зардалд нийгмийн даатгалын сангаас олгох оршуулгын тэтгэмжийн 75 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн тусламж олгох.

2/ 5 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:

5.6. Орон гэргүй бүрэн хараагүй, бүрэн хэлгүй дүлий, одой иргэн болон байнгын асаргаа шаардлагатай хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэнд гэр олгох, орон сууцны нөхцөл сайжруулах арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг Засгийн газар тухайн жилийн улсын төсөвт тусгана."

3/ 8 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

"8.4. Аж ахуйн нэгж, байгууллагад хараагүй хүнийг ажиллуулах ажлын байрны жагсаалтыг Засгийн газар батална."

4/ 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 7 дахь заалт:

"9.3.7. хараагүй хүнд зориулсан брайль болон томруулсан үсэгтэй ном, сурах бичиг, сонин, сэтгүүл хэвлэх зардлыг нийгмийн халамжийн сангаас гаргах."

5/ 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"10.2. Аймаг, дүүргийн эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс нь нарийн мэргэжлийн /дотор, мэдрэл, мэс засал, ерөнхий эмч/, нийгмийн даатгалын магадлагч эмч, аймаг, дүүргийн нийгмийн халамжийн байгууллагын болон ажил олгогчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх ашгийг хамгаалах байгууллагын төлөөллөөс бүрдэнэ."

2 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 5.1.4-ийн "ортопед" гэсний өмнө "болон худалдан авсан", мөн заалтын "үнийг" гэсний дараа "5 жил тутам нэг удаа 100 хувь", 5.1.6-ийн "эрхийн бичгийн" гэсний өмнө "нэг талын унааны зардал", 7.1-ийн "эрхтэй" гэсний дараа "бөгөөд тэдгээрийг бүх шатны боловсрол эзэмшихэд төрөөс дэмжлэг үзүүлнэ", 7.8-ын "байгууллагын" гэсний дараа "удирдах болон", 9.3.2-ын "орчуулгатай гаргах" гэсний дараа, урсгал

мэдээлэл явуулах, бичгэн мэдээллийг хараагүй хүнд зориулж нэвтрүүлэгч унших", 10.3-ын "иргэн" гэсний өмнө "хүүхэд ба" гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн дараахь зүйл, хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 6 дугаар зүйл:

"6 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний сэргээн засалт

6.1. Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан хүн нийгмийн харилцаанд оролцох, өөрөө өөртөө үйлчилж сурах, бие даан хөгжих чадвар эзэмших зорилгоор сэргээн засах үйлчилгээнд хамрагдах эрхтэй. Сэргээн засах үйлчилгээ нь эрүүл мэнд, мэргэжил, боловсрол, хөдөлмөр, нийгмийн болон сэтгэл зүйн гэсэн төрөлтэй байна.

6.2. Энэ хуулийн 6.1-д заасан үйлчилгээг сэргээн засах үйлчилгээ үзүүлдэг эмчилгээ, сувилгааны, сургалтын байгууллага болон протез, ортопедийн хэрэгслийн үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж үзүүлнэ.

6.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний сэргээн засах үйлчилгээг иргэн, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж, зардлыг хэсэгчлэн буюу бүрэн санхүүжүүлж болно."

2/ 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

"1.1. Энэ хуулийн зорилт нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг нийгмийн харилцаанд аливаа ялгаваргүйгээр тэгш оролцуулах нөхцлийг бүрдүүлэх, тэдний өвөрмөц хэрэгцээнд түшиглэсэн нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлэх, энэ талаар иргэн, хуулийн этгээдийн хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино."

3/ 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

"3.1. Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогийн улмаас бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь бүрэн болон 12 сараас дээш хугацаагаар хязгаарлагдсан хүнийг "хөгжлийн бэрхшээлтэй" гэж ойлгоно."

4/ 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт:

"5.1.1 бүрэн хараагүй, бүрэн хэлгүй дүлий, одой иргэн болон байнгын асаргаа шаардлагатай хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэнд орон сууцны хөлс төлөхөд,

хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлш худалдан авахад нь жилд нэг удаа мөнгөн тусламж олгох;

5/10 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг :

"10.1. 16 насанд хүрээгүй хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн эмч нарын хяналтын комисс, 16 насанд хүрсэн иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээг эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс тус тус тогтооно.

10.2. Энэ хуулийн 10.1-д заасан комиссын дүгнэлтийг үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон иргэнийг бүртгэн үнэмлэх олгох үүргийг аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах байгууллагын оролцоотойгоор хэрэгжүүлнэ."

4 дүгээр зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 5.1.2-ын "хоёр удаа" гэснийг "3 жил тутам нэг удаа", 5.1.3-ын "эхний удаа" гэснийг "5 жил тутам нэг удаа", 5.1.3, 5.1.4-ийн "нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авах эрх үүсээгүй" гэснийг "үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез хийлгэх, сэргээн засалттай холбогдсон хөнгөлөлт авах эрх үүсээгүй", 5.1.5-ын "харах, сонсох, ярих боломж нь хязгаарлагдмал сурагч" гэснийг "хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд", 5.1.6-ын "нэн ядуу

амьдралтай өрхийн" гэснийг "эмчилгээ, сувилгаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез хийлгэх, сэргээн засалттай холбогдсон хөнгөлөлт авах эрх үүсээгүй", 5.1.7-ийн "нэн ядуу амьдралтай өрхийн" гэснийг "хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн болон", 5.1.8-ын "иргэнтэй өрхийн суурин телефон утасны төлбөрт" гэснийг "иргэний харилцаа холбооны зардалд", 5.2-ын "Авто тээврийн тухай хуулийн 12.2-т заасны дагуу" гэснийг "орон нутгийн харъяалал харгалзахгүйгээр", 7.5-ын "энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэнийг аймаг, дүүргийн эмнэлэг-хөдөлмөрийн магадлах комисс" гэснийг "хүүхэд ба иргэнийг эрүүл мэндийн байгууллагын нарийн мэргэжлийн эмч нарын хяналтын комисс", 11.3.1-ийн "шийдвэр гаргах, эсхүл уг асуудлаар дээд шатны байгууллагад" гэснийг "асуудлаар холбогдох байгууллагад", 10.2,10.3,10.4,10.5 гэсэн хэсгийн дугаарыг "10.3,10.4,10.5,10.6." гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 5.1.3-ын "хоёр дахь удаа 50 хувь", 5.1.4-ийн "ядуу амьдралтай өрхийн", 5.1.7-ийн "4 хүртэлх насны", 5.1.8-ын "ядуу амьдралтай, хөдөлмөрийн чадвартай гишүүнгүй", 5.2-ын "буюу хөнгөлөлттэй үнээр", 9.3.2-ын "мэдээллийн" гэснийг тус тус хассугай.

МОНГОЛУЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд дор дурдсан агуулгатай зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/ "12" дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлогт тохирсон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээ зохион байгуулах

12.11. Хөдөлмөрийн зах зээлд бие даан оролцох боломжгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор байгуулагдсан хөдөлмөр сургалтын төв, аж ахуйн нэгж, байгууллагын дэргэдэх үйлдвэрлэлийн тусгай цех, тасгийн үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг үзүүлж болно.

12.12. Хөдөлмөр эрхлэлтийн алба нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлогт тохирох ур

чадварыг сорилын аргаар тодорхойлж, дүгнэлт гаргасны үндсэн дээр хөдөлмөрт бэлтгэх үйлчилгээ үзүүлнэ.

12.13. Хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байраар хангасан, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэсэн ажил олгогчийг тусгай болзлын дагуу шагнаруулна."

2/ 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт:

"3.1.7. "хөгжлийн бэрхшээлтэй иргэн" гэж Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 3.1 дэх хэсэгт заасан хөдөлмөрийн насны, хөдөлмөр эрхлэх чадварыг нь хөдөлмөр эрхлэлтийн албанаас сорилын аргаар тодорхойлсон иргэнийг;"

3/ 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалт:

"4.2.4. хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөрлөх тэгш боломжийг хангах."

4/ 5 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 4 дэх заалт:

"5.3.4. хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлогт тохирсон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих."

5/ 8 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

"8.5. Хөдөлмөр эрхлэлтийн орон нутгийн алба нь ажилд зуучлагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ажил олгогчтой гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавина."

6/ 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 6, 7 дахь заалт:

"9.1.6. хөдөлмөр эрхлэлтийн орон нутгийн албанд бүртгэлтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэн;

9.1.7. сургууль завсардсан, насанд хүрээгүй хүн."

7/ 11 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг:

"11.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг 24 сараас доошгүй хугацаагаар ажлын байраар хангасан ажил олгогчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5-10 дахин нэмэгдүүлсэн хэмжээний урамшууллыг ажиллуулсан хугацааг харгалзан олгоно."

8/ 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалт:

"15.1.9. хөгжлийн бэрхшээлтэй иргэний онцлогт тохирсон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих."

9/ 22 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

"22.5. Ажил олгогч нь Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлд заасны дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар хөдөлмөр эрхлэлтийн орон нутгийн албанд улирал тутам мэдээ, тайлан ирүүлнэ."

2 дугаар зүйл. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"11.1.2.Хөдөлмөрийн чадвараа 50-иас дээш хувиар алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэн;"

3 дугаар зүйл. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 7.1-ийн "хангах" гэсний дараа "хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрт бэлтгэх", 12.2-ын "цэвэрлэх" гэсний дараа "хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тусгай зориулалтын зам, орц, гарцыг барих", 10.1-ийн "эрхлэгчид" гэсний дараа "хөгжлийн бэрхшээлтэй иргэнд" гэж тус тус нэмсүгэй.

4 дүгээр зүйл. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн "5.3.4" гэсэн заалтын дугаарыг "5.3.5" гэж өөрчилсүгэй.

**• МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй:

1/ 111 дүгээр зүйлийн 6, 7 дахь хэсэг:

"111.6. Аж ахуйн нэгж, байгууллага тогтоосон төлбөрийг 24 сар тасралтгүй төлсөн тохиолдолд дараагийн 12 сард ногдох төлбөрийг чөлөөлнө.

111.7. Аж ахуйн нэгж, байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхлэх боломжтой ажил, мэргэжлийн жагсаалтыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална."

2 дугаар зүйл. Хөдөлмөрийн тухай хуулийн 111.3 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 111 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:

"111.3. Энэ хуулийн 111.2-т заасан төлбөрийг аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын тоо, төлбөрийн нийт хэмжээнээс хамааран Засгийн газраас тогтооно."

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

ОЛОН НИЙТИЙН РАДИО, ТЕЛЕВИЗИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Олон нийтийн радио, мэдээллийг хараагүй иргэнд зориулан телевизийн тухай хуулийн 9, 18 дугаар зүйлд дор нэвтрүүлж байна.

1/9 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг:

"9.6. Олон нийтийн радио, телевизийн мэдээллийн болон сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлэг нь дохионы хэлний орчуулгатай гарах ба урсгал мэдээлэл явуулах, бичгэн

2/ 18 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

18.5. Энэ хуулийн 18.1-д заасан үйлчилгээний хөлснөөс бүрэн хараагүй, бүрэн хэлгүй дүлий иргэнтэй өрх чөлөөлөгдөнө."

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

ЭХ, ХҮҮХДЭД ТЭТГЭМЖ ОЛГОХ, ХҮҮХЭД, ЭХ, ГЭР БҮЛД МӨНГӨН ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эх, хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд, эх, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай хуулийн 2, 8, 9 дүгээр зүйлд дор дурдсан агуулга бүхий хэсгийг нэмсүгэй:

асран хамгаалагч, үрчилж авсан эх нь тэтгэмжийг үргэлжлүүлэн авах эрхтэй.", 4.7-ийн "тэтгэмж" гэсний дараа", 4.3-д заасан мөнгөн тусламж" гэж тус тус нэмсүгэй.

1/2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө."

3 дугаар зүйл. Эх, хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд, эх, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалт, 6.8 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

2/ 8 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

"8.4. Энэ хуульд заасан тэтгэмж олгох, мөнгөн тусламж үзүүлэх журмыг **Засгийн газар** батална."

1/6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалт:

"6.1.3. тухайн сум, хороонд оршин суугааг нотолсон сум, хорооны Засаг даргын тодорхойлолт.

3/ 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:

"9.3. Хуурамч баримт бичиг бүрдүүлэх, худал мэдээлэх зэргээр энэ хуульд заасан тэтгэмж, мөнгөн тусламж тогтоолгосон гэм буруутай этгээдээр эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хохирлыг нөхөн төлүүлнэ."

2/6 дугаар зүйлийн 8 дахь хэсэг:

"6.8. Сумын Засаг дарга, дүүргийн нийгмийн халамж, үйлчилгээний байгууллага нь энэ хуулийн 6.6, 6.7-д заасан баримт бичгийг үндэслэн тэтгэмж олгох, мөнгөн тусламж үзүүлэх тухай захирамж, тушаал гаргана."

2 дугаар зүйл. Эх, хүүхдэд тэтгэмж олгох,

хүүхэд, эх, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай хуулийн 4. 6-ын "тэтгэмж" гэсний дараа "4.3-д заасан мөнгөн тусламж", 4.4-ийн "авах эрхтэй." гэсний дараа "Хэрэв эх хүүхдээ төрүүлсний дараа нас барсан бол уг хүүхдийн эцэг, эсхүл хууль ёсны

4 дүгээр зүйл. Эх, хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд, эх, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

ХУДАЛДААНЫ ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн Газар, Кувейт Улсын Засгийн газар хооронд 2007 оны 7 дугаар сарын 30-ны өдөр байгуулсан Худалдааны хэлэлцээрийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, ОЛОН УЛСЫН ХӨГЖЛИЙН АССОЦИАЦИ ХООРОНД БАЙГУУЛСАН "ТОГТВОРТОЙ АМЬЖИРГАА-2" ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТИЙН ГЭРЭЭГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар, Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд 2007 оны 12 дугаар сарын 19-ний өдөр байгуулсан "Тогтвортой амьжиргаа-2" төслийн санхүүжилтийн гэрээг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр

Улаанбаатар хот

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуульд дор дурдсан агуулгатай бүлэг, заалт нэмсүгэй. **34 дүгээр зүйл.** Мэдээллийн сангийн тогтолцоо

1/ Долдугаар бүлэг:

1. Мэдээллийн сан нь дараахь ангилалтай байна:

“ДОЛДУГААР БҮЛЭГ”

- 1/ улсын;
- 2/ аймаг, нийслэлийн;
- 3/ сум, дүүргийн.

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭДЭЭЛЛИЙН САН

33 дугаар зүйл. Мэдээллийн сангийн хэлбэр

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан мэдээллийн сан нь нэгдмэл байна.

1. Мэдээллийн санг цахим хэлбэрээр бүрдүүлнэ.

3. Мэдээллийн санг бүрдүүлэх, боловсруулах, түгээх, ашиглах, хадгалах, хамгаалах журам болон эх мэдээний дэлгэрэнгүй жагсаалтыг Засгийн газар батална.

2. Мэдээллийн сангийн мэдээлэл нь өгөгдөл, дуу авиа, дүрс бичлэг, зураг, график, бичгийн хэлбэртэй байна. Энэ зүйлд заасан зурган мэдээлэл нь Засгийн газраас баталсан солбилцол, өндрийн тогтолцоонд үндэслэгдэнэ.

35 дугаар зүйл. Мэдээллийн сангийн бүрдэл

3. Мэдээллийн сангийн өгөгдөл тоон хэлбэртэй байна.

1. Улсын мэдээллийн сан дараахь зүйлийн талаархи мэдээллээс бүрдэнэ:

4. Хуульд өөрөөр заагаагүй бол мэдээллийн сан олон нийтэд нээлттэй байна.

- 1/ газар, түүний хөрс;
- 2/ газрын хэвлий, ашигт малтмал;
- 3/ ус, рашаан;

- 4/ ой;
- 5/ байгалийн ургамал;
- 6/ амьтан;
- 7/ агаар, түүний бохирдол;
- 8/ уур амьсгал;
- 9/ байгалийн гамшиг;
- 10/ химийн хорт болон аюултай бодис;
- 11/ хог хаягдал;
- 12/ тусгай хамгаалалттай газар нутаг;
- 13/ байгаль орчны эрх зүй;
- 14/ байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ;
- 15/ байгаль орчны бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт;
- 16/ байгаль орчны статистик мэдээлэл, тайлан;
- 17/ байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардал;
- 18/ байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, хүний нөөц;
- 19/ мета мэдээллийн сан;
- 20/ байгаль орчны талаархи бусад мэдээлэл.

2. Аймаг, нийслэлийн мэдээллийн сан энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1-7, 9-12, 14-18, 20-д заасан зүйлийн талаархи мэдээллээс бүрдэнэ.

3. Сум, дүүргийн мэдээллийн сан энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1-6, 9-12, 14, 15, 17, 18, 20-д заасан зүйлийн талаархи мэдээллээс бүрдэнэ.

36 дугаар зүйл. Мета мэдээллийн сан

1. Байгаль орчны мета мэдээллийн сан дараахь мэдээллээс бүрдэнэ.

- 1/ мэдээллийн нэр, товч тайлбар;
- 2/ мэдээллийн чанарын тодорхойлолт;
- 3/ мэдээллийн үндсэн эх сурвалж;
- 4/ мэдээллийн тойм дүрслэл, солбилцлын тогтолцоо;
- 5/ мэдээллийн хэрэглээ, түгээлт.

2. Байгаль орчинтой холбоотой мэдээлэл бүрдүүлдэг иргэн, төрийн болон төрийн бус байгууллага энэ хуулийн 35 дугаар зүйлийн 1 дэх

хэсэгт заасан мэдээллийг бүрдүүлэх, шинэчлэх бүрд мета мэдээллийг бүрдүүлж улсын мэдээллийн санд төвлөрүүлнэ.

37 дугаар зүйл. Мэдээллийн санд мэдээлэл төвлөрүүлэх үүрэг бүхий байгууллага, хэрэгжүүлэх хугацаа

1. Энэ хуулийн 35 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан мэдээллийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага жил бүрийн 2 дугаар сарын 20-ны дотор улсын мэдээллийн санд төвлөрүүлнэ.

2. Энэ хуулийн 35 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т заасан мэдээллийг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга жил бүрийн 3 дугаар сарын 1-ний дотор улсын мэдээллийн санд төвлөрүүлнэ.

3. Энэ хуулийн 35 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 4, 7-д заасан мэдээллийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор улсын мэдээллийн санд төвлөрүүлнэ.

4. Энэ хуулийн 35 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, 6-д заасан мэдээллийг эрдэм шинжилгээний болон тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор улсын мэдээллийн санд төвлөрүүлнэ.

5. Энэ хуулийн 35 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8, 9-д заасан мэдээллийг ус цаг уур, орчны хяналт шинжилгээ болон онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гамшгийн нөхцөл байдал үүссэн тухай бүр улсын мэдээллийн санд төвлөрүүлнэ.

6. Энэ хуулийн 35 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10-т заасан мэдээллийг байгаль орчин, геологи, уул уурхай болон тухайн асуудал эрхэлсэн бусад төрийн захиргааны төв байгууллага жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор улсын мэдээллийн санд төвлөрүүлнэ.

7. Энэ хуулийн 35 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 11, 12-т заасан мэдээллийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг дарга

жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор улсын мэдээллийн санд төвлөрүүлнэ.

8. Энэ хуулийн 35 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 13-18-д заасан мэдээллийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухай бүр улсын мэдээллийн санд төвлөрүүлнэ.

38 дугаар зүйл. Мэдээллийн сангийн үйл ажиллагааг хангах байгууллага

1. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мэдээллийн сангийн үйл ажиллагааг улсын хэмжээнд удирдан зохион байгуулна.

2. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд байгаль орчны мэдээллийн төв байх бөгөөд уг төв нь улсын мэдээллийн сангийн өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлэх төрийн үйлчилгээний байгууллага байна.

39 дүгээр зүйл. Байгаль орчны мэдээллийн төвийн бүрэн эрх

1. Байгаль орчны мэдээллийн төв дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/мэдээллийн сангийн үйл ажиллагааны талаархи хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;

2/мэдээллийн санг бүрдүүлэх, баяжуулах, хадгалах, хамгаалах, шинэчлэх, ашиглах үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

3/мэдээллийн сангийн хүрээнд программ хангамж, техник технологи, хүний нөөцийн нэгдмэл бодлого хэрэгжүүлэх, тэдгээрийг сургаж бэлтгэх, мэргэшүүлэх;

4/хэрэглэгчийг мэдээллийн сангаас мэдээлэл авах эрхийг хэрэгжүүлэх нөхцөлийг хангах;

5/нийтийн хэрэгцээний болон хоёрдогч мэдээллийг бий болгоход шаардлагатай мэдээлэл боловсруулах;

6/мэдээллийн сангийн өгөгдөл, мэдээлэлд бүртгэл хөтлөх, баримтжуулах;

7/мэдээллийн сангийн мэдээллийг энэ хуулийн 37 дугаар зүйлд зааснаас бусад иргэн, хуулийн этгээдээс цуглуулах, сонгох, нягтлан шалгах ажлыг зохион байгуулах;

8/мэдээллийн үнэн зөв, мэдээллийн сангийн шуурхай байдал, хэвийн ажиллагаа, хамгаалалт, хадгалалт, нууцлалт, хуулбарлалтыг хариуцах;

9/мэдээллийн сангийн нөөц хувь бүрдүүлэх;

10/мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах;

11/мэдээллийн сан бүрдүүлэх асуудлаар мэдээлэл бүрдүүлэх, төвлөрүүлэх үүрэг бүхий байгууллагад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;

12/мэдээллийн санд өөрчлөлт хийх, мэдээлэл бүрдүүлэх, мэдээллийн сангийн талаархи тайланг жил бүр гаргах;

13/мэдээллийн санд халдлага, гэмтэл гарсан даруйд холбогдох байгууллагад мэдэгдэх, түүний хэвийн үйл ажиллагааг сэргээх;

14/мэдээллийн сангийн асуудлаар гадаадын болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах;

15/мэдээллийн санг зориулалтын байр, программ хангамж, компьютер, тоног төхөөрөмжөөр хангах, шаардлагатай өгөгдөл, мэдээлэл худалдан авахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн улсын төсөвт тусгуулах.

40 дүгээр зүйл. Мэдээллийн санд мэдээлэл төвлөрүүлэх үүрэг бүхий байгууллагын бүрэн эрх

1. Энэ хуулийн 37 дугаар зүйлд заасны дагуу улсын мэдээллийн санд мэдээлэл төвлөрүүлэх үүрэг бүхий байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/холбогдох мэдээллийг бүрдүүлж, улсын мэдээллийн санд цахим хэлбэрээр буюу сүлжээгээр нийлүүлэх, техникийн хувьд боломжгүй бол мэдээлэл зөөгч хэрэгслээр өгөх;

2/байгаль орчны өгөгдөл, мэдээллийг шинэчлэх, өөрчлөлт оруулах, шинэ өгөгдөл, мэдээллээр мэдээллийн санг баяжуулах;

3/байгаль орчны өгөгдөл, мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хариуцах;

4/байгаль орчны өгөгдөл, мэдээллийн анхдагч боловсруулалтыг хариуцах;

5/байгаль орчны өгөгдөл, мэдээллийн нэмэлт, өөрчлөлт, шинэчлэлтийн тухай байгаль орчны мэдээллийн төвд ажлын 7 өдөрт багтаан мэдэгдэх;

6/улсын мэдээллийн санд мэдээлэл төвлөрүүлэх техник, технологийн нөхцөлийг бүрдүүлэх, холбогдох зардлыг хариуцах.

41 дүгээр зүйл. Мэдээллийн санг хэрэглэгчийн эрх, үүрэг

1.Мэдээллийн сангийн хэрэглэгч дараахь эрх, үүрэгтэй:

1/мэдээллийн сангийн өгөгдөл, мэдээллийг ашиглан эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх, лавлагааны мэдээлэл бэлтгэх болон бусад хэлбэрээр ашиглахдаа мэдээлэл эзэмшигчийн нэрийг ишлэл болгох;

2/мэдээллийн сангийн үйл ажиллагаа болон өгөгдөл, мэдээллийн талаар гомдол гаргах.

42 дугаар зүйл. Мэдээллийн санг бүрдүүлэх ерөнхий шаардлага

1.Мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах, түгээх үйл ажиллагаа, техник, технологи нь мэдээлэл, харилцаа холбоо, технологийн төрийн нэгдсэн бодлоготой уялдсан байна.

2.Мэдээллийн сангийн агуулга, нэр төрөл, хамрах хүрээ нь хэрэглэгчийн эрэлт хэрэгцээгээр тодорхойлогдоно.

3.Мэдээллийн сангийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх байгууллагын техник, технологийн шийдэл нь мэдээллийн нэгдмэл байдлыг хангахад чиглэгдэнэ.

43 дугаар зүйл. Мэдээллийн сангийн үйл ажиллагаанд хориглох зүйл

1.Мэдээллийн сангийн үйл ажиллагаанд дараахь зүйлийг хориглоно:

1/мэдээллийн сангийн өгөгдөл, мэдээллийг өөрчлөх, устгах, хулгайлах;

2/мэдээллийн сангийн программ хангамжийг өөрчлөх, устгах, эвдэх;

3/мэдээллийн сангийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, сүлжээний найдвартай үйл ажиллагааг санаатай болон санамсаргүйгээр алдагдуулах, эвдэх, гэмтээх;

4/мэдээллийн санд вирус тараах;

5/мэдээллийн санд агуулагдаж буй иргэн, хуулийн этгээдийн нууцтай холбоотой мэдээллийг задруулах;

6/мэдээллийн сангаас авсан мэдээллийг эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр арилжааны зорилгоор ашиглах, бусдад дамжуулах, худалдах;

7/мэдээллийн сангаас санаатай болон болгоомжгүйгээр мэдээлэл хуулбарлах, ишлэлгүйгээр ашиглах;

8/ашиглах хүрээг нь хязгаарласан өгөгдөл, мэдээлэлд хууль бусаар нэвтрэх, тэдгээрийг өөрчлөх, хуулбарлах, устгах;

9/мэдээллийн санд хандах эрхийг хууль бусаар олж авах, бусдад дамжуулах;

10/мэдээллийн сангийн ажилтан хуулиар хүлээсэн давуу эрхтэй холбоотойгоор өгөгдөл, мэдээлэл болон мэдээллийн сангийн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг алдагдуулах.

44 дүгээр зүйл. Мэдээллийн сангийн санхүүжилт, төлбөрийн нөхцөл

1.Мэдээллийн сан төрийн өмч байх бөгөөд түүний үйл ажиллагааг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

-2.Мэдээллийн сангийн мэдээлэл нь төлбөртэй болон төлбөргүй байна. Төлбөргүй болон нийтэд зориулсан мэдээллийн жагсаалтыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

3.Иргэн, хуулийн этгээд өөрийн хөрөнгөөр цуглуулж бүрдүүлсэн өгөгдөл, мэдээллийн тухай мета мэдээллийг улсын санд төлбөргүй өгөх үүрэгтэй.

4.Байгаль орчны мэдээллийн төв энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан иргэн, хуулийн



этгээдээс шаардлагатай мэдээллийг худалдан авч болно.

5.Иргэн, байгууллага, хуулийн этгээд нь улсын төсөв, шинжлэх ухаан, технологийн сан, олон улсын болон гадаадын зээл, тусламжийн хүрээнд бүрдүүлсэн байгаль орчны өгөгдөл, мэдээллийг улсын мэдээллийн санд үнэ төлбөргүй төвлөрүүлэх үүрэгтэй.

6.Мэдээллийн сангийн сургалт, танин мэдэхүй, эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангахтай холбоотой нийтэд зориулсан мэдээллийг иргэн, хуулийн этгээд төлбөргүй ашиглах эрхтэй.

7.Энэ зүйлд заасан төлбөртэй мэдээллийн орлогын 50 хүртэл хувийг мэдээллийн санг шинэчлэх, үйлчилгээний хүрээг нэмэгдүүлэх, түүний хүчин чадлыг сайжруулахад зарцуулна."

2/ 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 9, 10 дахь заалт:

"9/ "байгаль орчны мэдээллийн сан" /цаашид "мэдээллийн сан" гэх/ гэж байгаль орчны өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэх, цуглуулах, дамжуулах, боловсруулах, ашиглах, хадгалах, баяжуулах, өөрчлөх, шинэчлэх, хамгаалах зэрэг үйл ажиллагааг хангах мэдээллийн технологийн иж бүрдлийг;

10/ "мета мэдээлэл" гэж мэдээний эх сурвалж, хариуцах этгээд, формат, масштаб, чанар, хамрах хүрээ, хугацаа, ашиглалт зэрэг өгөгдлийн талаархи мэдээллийн багцыг."

3/ 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 13 дахь заалт:

"13/ байгаль орчны мэдээллийн сангийн үйл ажиллагааны талаархи хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж, хэрэгжилтэд нь хяналт тавих;"

4/ 38 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 5, 6 дахь заалт:

"5/ энэ хуулийн 37, 40 дүгээр зүйлд заасны дагуу холбогдох мэдээллийг улс, аймаг, нийслэл, сум, дүүргийн мэдээллийн санд төвлөрүүлээгүй, мэдээллийн санд өгөх тайлан, мэдээллийг энэ хуульд заасан хугацаанд гаргаж өгөөгүй, буруу мэдээлэл өгсөн бол холбогдох албан тушаалтныг 20000-60000, хуулийн этгээдийг 100000-200000 төгрөгөөр торгох;

6/ энэ хуулийн 43 дугаар зүйлийг санаатайгаар зөрчсөн иргэнийг 20000-50000, албан тушаалтныг 30000-60000, хуулийн этгээдийг 150000-250000 төгрөгөөр торгох."

2 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хоёрдугаар бүлгийн гарчгийг "БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ, СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ", "ДОЛДУГААР БҮЛЭГ" гэснийг "НАЙМДУГААР БҮЛЭГ", 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 13 дахь заалтын дугаарыг "14", 33-39 дүгээр зүйлийн дугаарыг "45-51", 38 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалтын "37 дугаар" гэснийг "49 дүгээр" гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 12 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр

Улаанбаатар хот

ОЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ойн тухай хуулийн 6.3-ын "12 дугаар зүйлд" гэснийг "Долдугаар бүлэг", 34.4, 34.5-ын "34 дүгээр" гэснийг "46 дугаар", 35.3-ын "35 дугаар зүйлийн" гэснийг "47 дугаар зүйлийн" гэж тус тус өөрчилсүгэй.

дүгээр сарын 31-ний өдөр батлагдсан Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2008 оны 01

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр

Улаанбаатар хот

ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 12.2.8-ын "36.2-т" гэснийг "48 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт" гэж өөрчилсүгэй.

орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2008 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр батлагдсан Байгаль

МОНГОЛУЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 02 дугаар сарын 01-ний өдөр

Улаанбаатар хот

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн хуульд дор дурдсан агуулгатай дараахь зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

хорих ялын доод хэмжээнээс доогуур хорих ял оногдуулж болох боловч ийнхүү хөнгөрүүлэн оногдуулах хорих ялын доод хэмжээ нь энэ хуулийн тусгай ангид тухайн гэмт хэрэгт оногдуулахаар заасан хорих ялын доод хэмжээний хоёрны нэгээс хэтрэхгүй байна."

1/55' дүгээр зүйл:

"55' дүгээр зүйл. Эрүүгийн хуулийн тусгай ангид зааснаас хөнгөрүүлж хорих ял оногдуулах

3/153' дүгээр зүйл:

"153' дүгээр зүйл. Бусдын эд хөрөнгөд болгоомжгүйгээр хохирол учруулах

55'. 1. Эрүүгийн хуулийн тусгай ангид заасны дагуу хорих ял оногдуулж болох гэмт хэрэг анх удаа үйлдсэн этгээд гэмт хэргийн хохирлыг нөхөн төлсөн буюу гэм хорыг арилгасан бол шүүх тухайн этгээдийн хувийн байдал, үйлдсэн хэргийнх нь шинж чанарыг харгалзан Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан хорих ялын доод хэмжээнээс доогуур хорих ял оногдуулж болох боловч ийнхүү хөнгөрүүлэн оногдуулах хорих ялын доод хэмжээ нь энэ хуулийн тусгай ангид тухайн гэмт хэрэгт оногдуулахаар заасан хорих ялын доод хэмжээний гуравны хоёроос хэтрэхгүй байна."

153'. 1. Бусдын эд хөрөнгөд болгоомжгүйгээр онц их хэмжээний хохирол учруулсан бол нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, хоёр зуун тавин нэгээс таван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ."

2/62' дүгээр зүйл:

"62' дүгээр зүйл. Насанд хүрээгүй этгээдэд Эрүүгийн хуулийн тусгай ангид зааснаас хөнгөрүүлж хорих ял оногдуулах

4/155' дүгээр зүйл:

"155' дүгээр зүйл. Нотариатч, эрхийн улсын бүртгэгч өмчлөгчийн эрхийг зөрчих

62'. 1. Эрүүгийн хуулийн тусгай ангид заасны дагуу хорих ял оногдуулж болох гэмт хэрэг анх удаа үйлдсэн насанд хүрээгүй этгээд гэмт хэргийн хохирлыг нөхөн төлсөн буюу гэм хорыг арилгасан бол шүүх тухайн этгээдийн хувийн байдал, үйлдсэн хэргийнх нь шинж чанарыг харгалзан Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан

155'. 1. Өмчлөх эрхийг хязгаарлах, шилжүүлэхтэй холбоотой илт хууль бус хэлцлийг нотариатч гэрчлэн баталсан, эрхийн улсын бүртгэгч бүртгэсний улмаас бусдад их хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасч, хөдөлмөрийн хөлсний доод



хэмжээг нэг зуун тавин нэгээс хоёр зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

155¹.2.Энэ хэргийг давтан буюу бүлэглэж үйлдсэн, түүнчлэн энэ хэргийн улмаас онц их хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг таван жил хүртэл хугацаагаар хасч, таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

5/156¹ дүгээр зүйл:

“156¹ дүгээр зүйл. Хоршооны тухай хууль тогтоомж зөрчих

156¹.1.Хоршооны тухай хууль тогтоомж зөрчсөний улмаас бусдад бага бус хэмжээний хохирол учруулсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

6/156¹ дугаар зүйл:

“156¹ дугаар зүйл. Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны тухай хууль тогтоомж зөрчих

156¹.1. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уг тусгай зөвшөөрөлд зааснаас өөр үйл ажиллагаа эрхэлсэн, өөрийн үйл ажиллагааны талаар буруу ташаа зар сурталчилгаа хийсэн, худал мэдээлэл өгсөн, Банк бус санхүүгийн байгууллагын тайлан тэнцэлд тусгаагүй эх үүсвэрийг өөрийн үйл ажиллагаанд ашигласны улмаас бусдад бага бус хэмжээний хохирол учруулсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэнэ.”

7/158¹ дүгээр зүйл:

“158¹ дүгээр зүйл. Даатгалын тухай хууль тогтоомж зөрчих

158¹.1.Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль тогтоомжоор тогтоосон журмыг зөрчсөний улмаас бусдад их хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуун тавин нэгээс хоёр зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

158¹.2. Энэ хэргийг давтан буюу бүлэглэж үйлдсэн түүнчлэн энэ хэргийн улмаас онц их хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг таван жил хүртэл хугацаагаар хасч, таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

8/178¹ дүгээр зүйл:

“178¹ дүгээр зүйл. Терроризм

178¹.1.Хууль бус зэвсэгт бүлэглэл, террорист этгээд өөрийн улс төр, шашин, үзэл суртлын зорилгыг хэрэгжүүлэхийн тулд нийгмийг, эсхүл түүний тодорхой хэсгийг айдаст автуулахаар иргэдийн амь нас, эрүүл мэндийн эсрэг хүчирхийлэл үйлдсэн, хүчирхийлэхээр заналхийлсэн, энэхүү үйлдлээрээ гоц халдварт өвчин, гал түймэр болон гамшгийн нөхцөлийг бүрдүүлсэн бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

178¹.2.Энэ хэргийг онц аюултай гэмт хэрэгтэн, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, энэ хэргийн улмаас хүний амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг учирсан бол хориос дээш хорин таван жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл цаазаар авах ял шийтгэнэ.”

9/178¹ дугаар зүйл:

“178¹ дугаар зүйл. Терроризмыг санхүүжүүлэх

178¹.1.Террорист байгууллага болон террорист ажиллагаанд зэргүүлэх урьдчилан

мэдсээр байж эд хөрөнгө хуримтлуулсан, шилжүүлсэн, зарцуулсан бол эд хөрөнгийг хурааж, таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

178².2.Энэ гэмт хэргийг давтан буюу бүлэглэж үйлдсэн, эсхүл их хэмжээгээр террорист байгууллага, террорист ажиллагааг санхүүжүүлсэн бол эд хөрөнгийг хурааж, арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

178³.3.Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, эсхүл онц их хэмжээгээр террорист байгууллага, террорист ажиллагааг санхүүжүүлсэн бол эд хөрөнгийг хурааж, арван таваас дээш хорин таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ."

10/ 178³ дугаар зүйл:

"178³ дугаар зүйл. Терроризмыг сурталчлах

178³.1.Терроризмыг сурталчилсан, террорист ажиллагаа явуулах, түүнд оролцохыг нийгэд уриалсан, өдөөн хатгасан, албадсан, энэ чиглэлээр сурталчилгааны материал бэлтгэсэн, тараасан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

178³.2.Терроризмыг сурталчлах гэмт хэргийг давтан, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, холбоо, цахим сүлжээ ашиглаж үйлдсэн бол гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ."

11/ 214¹ дүгээр зүйл:

"214¹ дүгээр зүйл. Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль тогтоомж зөрчих

214¹.1.Химийн хорт болон аюултай бодисыг зөвшөөрөлгүйгээр экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, хадгалах, худалдах, худалдан авах, тээвэрлэх, ашиглах болон бусдад дамжуулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

214¹.2.Химийн хорт болон аюултай бодисыг зориулалт бусаар ашигласан, бусдын эрүүл мэнд, байгаль орчинд хүнд хор уршиг, их хэмжээний хохирол учруулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавин нэгээс таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ."

12/ 268¹ дүгээр зүйл:

"268¹ дүгээр зүйл. Мөнгө угаах

268¹.1.Зэвсэг, хар тамхи, хүн худалдаалах, эсхүл хуурамч мөнгөн тэмдэгт үйлдвэрлэж олсон орлого, түүнчлэн зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл, терроризмыг санхүүжүүлэх зорилготой илт хууль бус эд хөрөнгө гэдгийг мэдсээр байж эх үүсвэрийг нь халхавчлах буюу нуун далдлах, эсхүл уг эд хөрөнгийг хууль ёсны болгох зорилгоор гүйлгээнд оруулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

268¹.2.Энэ хэргийг давтан буюу бүлэглэж, эсхүл албан тушаалын байдлаа ашиглаж үйлдсэн, түүнчлэн их хэмжээний орлого олсон бол эд хөрөнгийг хурааж, таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

268¹.3.Энэ хэргийг зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, эсхүл онц их хэмжээний орлого олсон бол эд хөрөнгийг хурааж, арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ."

13/ 61 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг:

"61.4.Тэнсэгдсэн ялтанд цагдаагийн байгууллага хяналт тавина."

14/ 61 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг:

"61.5.Тэнсэгдсэн ялтан хянан харгалзах хугацаанд захиргааны шийтгэл хүлээсэн бол цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн хорих ялыг биечлэн эдлүүлэх эсэхийг шүүх шийдвэрлэнэ."



15/125 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"125.2. Энэ хэргийг давтан, бүлэглэж үйлдсэн, уг хэргийн улмаас хүнд хор уршиг учирсан, эсхүл насанд хүрээгүй, бага насны хүүхдийг далимдуулан бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан бол таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ."

16/ 208 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"208.2. Энэ хэргийг давтан, эсхүл улсын тусгай хамгаалалттай газар нутагт үйлдсэн, их буюу онц их хэмжээний хохирол учирсан, хүний эрүүл мэнд, амь нас хохирсон бол гурваас дээш таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ."

17/215 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

"215.4 Энэ хэргийн улмаас хоёр ба түүнээс дээш хүний амь нас хохирсон бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг таван жил хүртэл хугацаагаар хасч, таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ."

18/ 251 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:

"251.3. Энэ хэргийн улмаас хохирогч нас барсан бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ."

19/ 126 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 5 дахь заалт:

"126.2.5 албан тушаал, эд хөрөнгийн болон өөр байдлаар эрхшээлдээ байгаа хүнийг;"

2 дугаар зүйл. Эрүүгийн хуулийн 10.1-ийн "хэргийн" гэсний дараа "бүрэлдэхүүний" гэж, 16.1-ийн "аюултай" гэсний дараа "гэм буруутай" гэж, 24.1.1-ийн "урьд нь хүнд гэмт хэрэг" гэсний дараа "санаатай", "дахин хүнд гэмт хэрэг" гэсний дараа "санаатай" гэж, 24.1.2-ын "хүнд буюу онц хүнд гэмт хэрэг" гэсний дараа "санаатай", "дахин онц хүнд гэмт хэрэг" гэсний дараа "санаатай" гэж, 24.1.3-ын "давтан" гэсний дараа "санаатай" гэж, 24.1.4-ийн "хэрэг" гэсний дараа "санаатай" гэж, 49.2-ын "тээврийн" гэсний дараа "хэрэгсэл, унаа хөсөг" гэж, 52.6-гийн " хорих ял эдэлж байсан" гэсний дараа " анх удаа онц хүнд гэмт хэрэг үйлдсэн " гэж, 52.7-гийн "онц хүнд" гэсний өмнө "Хоёр ба түүнээс дээш удаа" гэж, 52.11-ийн "шийтгүүлсэн" гэсний дараа

"эрэгтэй" гэж, 59.3-ын "болно." гэсний дараа "Цагдан хоригдсон этгээдэд торгох ял оногдуулсан бол цагдан хоригдсон нэг хоногийг тухайн үед мөрдөгдөж байгаа нэг насрын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүүлж, торгох ялаас хасч тооцно." гэсэн хоёр дахь өгүүлбэр, 60.2; 60.3-ын "хүнд төрлийн ялын" гэсний дараа "доод хэмжээний" гэж, 63.1-ийн "болно." гэсний дараа "Энэ хугацаанд ялтанд цагдаагийн байгууллага хяналт тавина." гэсэн хоёр дахь өгүүлбэр, 96.1-ийн "хүүхэд дутуу гаргуулсан" гэсний дараа "буюу ураг зулбуулсан" гэж, 107.1-ийн "учирсан бол" гэсний дараа "хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох," гэж, 114.1-ийн "оролцуулсан бол" гэсний дараа "хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох," гэж, 114.2-ын "хоёр зуун" гэсний дараа "тавин" гэж, 117.1-ийн "төөрүүлсэн бол" гэсний дараа "хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох," гэж, 124.2-ын "зуучилсан," гэсний дараа "биеэ үнэлэхийг байнга зохион байгуулсан," гэж, 128.2-ын "Энэ" гэсний дараа "хуулийн 128.1-д заасан" гэж, 129.1-ийн "авсан бол" гэсний дараа "хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох," гэж, 129.2-ын "давтан," гэсний дараа "бүлэглэж," гэж, 132.1-ийн "торгох" гэсний дараа, эсхүл нэгээс гурван сарын хугацаагаар баривчлах " гэж, 139.1-ийн "мэдээллийг" гэсний дараа "олон" гэж, 145.2-ын "хулгайлсан бол" гэсний дараа "эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр" гэж, 145.3-ын "далимдуулж үйлдсэн бол" гэсний дараа "эд хөрөнгийг хурааж," гэж, 145.4-ийн "учирсан бол" гэсний дараа "эд хөрөнгийг хурааж," гэж, 147.2-ын "учирсан бол" гэсний дараа "эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр" гэж, 149.2-ын "сүрдүүлсэн бол" гэсний дараа "эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр " гэж, 149.3-ын "сүрдүүлсэн бол" гэсний дараа "эд хөрөнгийг хурааж," гэж, 150.3-ын "бусдад" гэсний дараа "их буюу" гэж, 154.2-ын "учирсан бол" гэсний дараа "хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуун нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох," гэж, 155.1-ийн "авсан" гэсний дараа "хадгалсан, борлуулсан" гэж, 161.2-ын "хохирол" гэсний дараа "хүнд хэр уршиг" гэж, 166.2-ын "хурааж," гэсний дараа "хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавин нэгээс таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй

тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл" гэж, 171.3-ын "хор уршиг" гэсний дараа "онц их хэмжээний хохирол" гэж, 172.1-ийн "баривчлах" гэсний дараа ".эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих" гэж, 172.2-ын "хор уршиг" гэсний дараа ",их буюу онц их хэмжээний хохирол" гэж, 175.1-ийн "нэвтрүүлсэн бол" гэсний дараа "эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр" гэж, мөн хэсгийн "торгох," гэсний дараа "хоёр зуун тавин нэгээс таван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх," гэж, 175.2-ын "нэвтрүүлсэн бол" гэсний дараа "эд хөрөнгийг хурааж," гэж, 176.1-ийн "байж" гэсний дараа "ашигласан," гэж, мөн хэсгийн "борлуулсан бол" гэсний дараа "хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох," гэж, 178.1-ийн "мэдээлсэн бол" гэсний дараа "хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл" гэж, 179.1-ийн "турхирсан бол" гэсний дараа "хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл" гэж, 183.1-ийн "эрхийг" гэсний дараа "гурван жил хүртэл хугацаагаар" гэж, 193.1-д "хийлгэх," гэсний дараа "гурваас дээш зургаан сарын хугацаагаар баривчлах," гэж, 211.2-ын "учирсан" гэсний дараа ",улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ойд үйлдсэн" гэж, 241.1-ийн "торгох" гэсний дараа ".эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах" гэж, 243.1-ийн "торгох" гэсний дараа ",эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах" гэж, 243.2-ын "торгох" гэсний дараа "гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах," гэж, 246.1-ийн "тусгай ангийн" гэсний дараа "87.2/ Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар төрийн нууц задруулах/," гэж, "177/Зандалчлах/," гэсний дараа "178/Терроризм/," гэж, 247.1-ийн "177/Зандалчлах/," гэсний дараа "178/Терроризм/," гэж, "225/Агаарын хөлөг авч зугтаах/," гэсний дараа "261.2/Хорих ял эдлэхээс зайлсхийх/," гэж, 253.2-ын "шүүгч" гэсний дараа "болон хойшлуулшгүй ажиллагаа явуулах эрх бүхий албан тушаалтан" гэж, 261 дүгээр зүйлийн гарчгийн "Шүүх," гэсний өмнө "Прокурорын хяналт," гэж, 261.1-ийн "ялтан" гэсний дараа "прокурорын хяналт," гэж, 263.2-ын "хохирол" гэсний дараа ",хүнд хор уршиг" гэж, 268.2-ын "их хэмжээний" гэсний дараа "хэцүү" гэж, "АРАВДУГААР ХЭСЭГ"-ийн гарчгийн "ЦЭРГИЙН" гэсний дараа "АЛБАНЫ ЭСРЭГ" гэж, 274 дүгээр

зүйлийн гарчгийн "Цэргийн" гэсний дараа "албаны эсрэг" гэж, 274.1-ийн "гэмт хэрэг" гэсний өмнө "албаны эсрэг" гэж, 274.4-ийн "цэргийн" гэсний дараа "албаны эсрэг" гэж, 288.1-ийн "хохирол" гэсний дараа ",хүнд хор уршиг", "баривчлах" гэсний дараа ",гурван жил хүртэл хугацаагаар хорих" гэж, 294.1-ийн "хохирол учирсан бол" гэсний дараа "гурваас дээш зургаан сарын хугацаагаар баривчлах, эсхүл" гэж, 294.2-ын "их" гэсний дараа "буюу онц их", "хохирол" гэсний дараа ",хүнд хор уршиг" гэж, 295.2-ын "хохирол" гэсний дараа ",хүнд хор уршиг" гэж, 302.1-ийн "хүргэсэн" гэсний дараа ",хүчээр сураггүй алга болгосон" гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл Эрүүгийн хуулийн зарим зүйл, хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/113 дугаар зүйл:

"113 дугаар зүйл. Хүн худалдаалах

113.1. Ашиг олох буюу мөлжих зорилгоор хүн худалдаалахдаа хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, хууран мэхэлсэн, эмзэг байдлыг нь далимдуулсан, түүнчлэн бусдыг элсүүлсэн, тээвэрлэсэн, дамжуулсан, орогнуулсан, хүлээн авсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

113.2. Энэ хэргийг:

113.2.1 насанд хүрээгүй хүнийг;

113.2.2 хоёр буюу түүнээс олон хүнийг;

113.2.3 хулгайлах;

113.2.4 эрх мэдлээ урвуулан ашиглах буюу эрхшээлдээ байгаа хүнийг;

113.2.5 давтан;

113.2.6 бүлэглэж буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавин нэгээс таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таваас



дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

113.3. Хүнийг хил давуулан худалдаалсан, эсхүл зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, уг хэргийн улмаас хүнд хор уршиг учирсан бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар:

1. Энэ хуулийн 113.1-д заасан "мөлжих" гэдгийг худалдагдсан хүний биеийг нь үнэлүүлэх зэргээр бэлгийн хүчирхийлэлд оруулах, боолчлох болон түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, албадан хөдөлмөр хийлгэх, эд эрхтнийг нь авч ашиглах гэсэн утгаар ойлгоно.

2. Энэ хуулийн 113.1-д заасан аливаа арга хэрэглэсэн бол хохирогч худалдагдахыг зөвшөөрсөн эсэхийг үл харгалзан гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ."

2/ 136 дугаар зүйл:

"136 дугаар зүйл. Хувь хүний нууцыг задруулах

136.1. Хуулиар хамгаалагдсан хувь хүний нууцыг мэдсэн этгээд задруулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

136.2. Хувь хүний нууцыг олон нийтэд тараасны улмаас бусдад хүнд хор уршиг учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ."

3/ 140 дүгээр зүйл:

"140 дүгээр зүйл. Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг зөрчих

"140.1. Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн бүтээлийг зөвшөөрөлгүй хуулбарлан нийтлүүлсэн, түгээсэн, борлуулсан, тэдгээрийн улмаас их хэмжээний орлого олсон бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс

хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ."

4/ 141 дүгээр зүйл:

"141 дүгээр зүйл. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын патент, ашигтай загварын гэрчилгээ эзэмшигчийн эрхийг зөрчих

141.1. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын патент, ашигтай загварын гэрчилгээ эзэмшигчийн эрхийг зөрчсөн эрхийн хамгаалалт хийгдсэн шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварыг ашиг олох зорилгоор зөвшөөрөлгүй ашигласан, үүний улмаас их хэмжээний орлого олсон бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ."

5/ 148 дугаар зүйл:

"148 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг залилан мэхлэж авах

148.1. Бусдын эд хөрөнгө, эсхүл түүнийг өмчлөх эрхийг хуурч мэхлэх, итгэл эвдэх аргаар олж авсны улмаас бага бус хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

148.2. Энэ гэмт хэргийг давтан, бүлэглэж буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, эсхүл албан тушаалын байдлаа ашиглаж үйлдсэн, түүнчлэн энэ хэргийн улмаас үлэмж хэмжээний хохирол учирсан бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

148.3. Энэ гэмт хэргийг урьд нь энэ хэрэгт болон хулгайлах, булаах, завших, дээрэмдэх гэмт

хэрэгт шийтгүүлсэн этгээд үйлдсэн, түүнчлэн энэ хэргийн улмаас их хэмжээний хохирол учирсан бол эд хөрөнгийг хурааж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавин нэгээс таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

148.4.Энэ гэмт хэргийг онц аюултай гэмт хэрэгтэн, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, түүнчлэн энэ хэргийн улмаас онц их хэмжээний хохирол учирсан бол эд хөрөнгийг хурааж, арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ."

6/198 дугаар зүйл:

"198 дугаар зүйл. Хууль бусаар эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдэрлэх, импортлох, хадгалах, худалдах, түгээх

198.1.Эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд эмчилгээнд хэрэглэхийг хориглосон, хугацаа дууссан эм, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэсэн, импортлосон, хадгалсан, худалдсан, түгээсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

198.2.Зохих зөвшөөрөлгүй этгээд хууль бусаар эм үйлдвэрлэх, импортлох, худалдах, түгээх үйл ажиллагаа явуулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуун нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

198.3.Энэ хэргийн улмаас хүний амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг учирсан бол таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ."

7/202 дугаар зүйл:

"202 дугаар зүйл. Агаар бохирдуулах

202.1.Үйлдвэрийн үйл ажиллагааны улмаас ялгарсан хүний эрүүл мэнд, байгаль орчинд хортой бодисыг цэвэршүүлэлгүй хаясан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин

нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

202.2.Агаарыг хүний эрүүл мэнд, байгаль орчинд хортой бодисоор бохирдуулсны улмаас үлэмж хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг зуун нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

202.3.Энэ хэргийн улмаас хүний амь нас хохирсон бол хоёроос дээш таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ."

8/203 дугаар зүйл:

"203 дугаар зүйл. Ан агнуурын тухай хууль тогтоомж зөрчих

203.1.Улсын тусгай хамгаалалттай газар нутагт болон хориотой үед, хориглосон арга, зэвсэг, хэрэгслээр ан амьтан агнасан, барьсны улмаас үлэмж хэмжээний хохирол учирсан, ховор ан амьтанг зохих зөвшөөрөлгүйгээр агнасан, барьсан, тэжээж гаршуулсан, тэдгээрийн түүхий эдийн зүйлийг хадгалсан, худалдсан, худалдан авсан, тэвэвэрлэсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

203.2.Энэ хэргийн улмаас их буюу онц их хэмжээний хохирол учирсан, нэн ховор ан амьтан агнасан, барьсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуун тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ."

9/207 дугаар зүйл:

"207 дугаар зүйл. Газрын хөрс, усыг бохирдуулах

207.1.Химийн бодис, бордоог экспортлох, импортлох, улсын хилээр дамжуулан тэвэвэрлэх, үйлдвэрлэх, хадгалах, худалдах, устгах, ашиглах,

тээвэрлэх журам зөрчсөн, үйлдвэрийн болон ахуйн хог хаягдлаар газрын хөрс, усыг бохирдуулж хүний эрүүл мэнд, байгаль орчинд үлэмж хэмжээний хохирол учруулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

10/214 дүгээр зүйл:

“214 дүгээр зүйл. Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох

214.1.Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох үйл ажиллагаа явуулж үлэмж хэмжээний хохирол учруулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хорин нэгээс тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

214.2.Энэ хуулийн 214.1-д заасан гэмт хэргийн улмаас их буюу онц их хэмжээний хохирол учирсан, эсхүл уг үйл ажиллагааг тусгай хамгаалалттай газар нутагт явуулсан бол эд хөрөнгийг нь хураах буюу хураахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

214.3.Тусгай зөвшөөрлийн дагуу ашигт малтмалын хайгуул, ашиглалт, олборлолтын үйл ажиллагаа явуулсан талбайд нөхөн сэргээлтийн ажил хийгээгүй, эсхүл химийн хорт болон аюултай бодис хэрэглэх журам зөрчсөний улмаас хүний эрүүл мэнд, мал, амьтан, байгаль орчинд их хэмжээний хохирол бусад хүнд хор уршиг учруулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг дөрвөн зуун тавиас таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

11/ 216 дугаар зүйл.

“216 дугаар зүйл. Зам тээврийн ослын үед жолооч үүргээ биелүүлэхгүй байх, зугтаах

216.1.Зам тээврийн осол гаргасан жолооч хохирсон хүнд яаралтай тусламж үзүүлэх, осол гарсан талаар зохих байгууллага, албан тушаалтанд мэдэгдэх үүргээ биелүүлээгүй бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хоёр жилийн хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

216.2.Жолооч зам тээврийн осол гарсан газрыг санаатай орхиж зугтаасан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс далан тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

12/ 211 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

“211.1.Зохих зөвшөөрөлгүйгээр ойд мод бэлтгэсэн, тээвэрлэсэн, худалдсан, худалдан авсан, хадгалсан, боловсруулсан, хамгаалалтын болон ашиглалтын бүсийн ойд хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулснаас бага бус буюу үлэмж хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуугаас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

13/ 212 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“212.1.Нэн ховор, ховор, ургамал, тэдгээрийн үр, эрхтнийг зохих зөвшөөрөлгүй бэлтгэсэн, худалдсан, худалдан авсан, хадгалсан, тээвэрлэсэн, улсын хилээр гаргасны улмаас бага бус буюу үлэмж хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

14/ 213 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“213.1.Гал болон түргэн шатамхай зүйлтэй болгоомжгүй харьцсаны улмаас ой, хээрийн түймэр гарч хүний амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг, их хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс

хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

15/ 213 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

“213.2. Ой, хээрийн түймэр санаатай тавьсны улмаас бага бус буюу үлэмж хэмжээний хохирол учирсан нь энэ хуулийн 84, 153 дугаар зүйлд заасан гэмт хэргийн шинжгүй бол гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

16/ 263 дугаар зүйлийн Тайлбар:

“Тайлбар: Энэ бүлэгт дурдсан төрийн албан тушаалтан гэдэгт төрийн байгууллагад удирдах, гүйцэтгэх албан тушаал эрхэлж байгаа этгээдийг хамааруулна.”

4 дүгээр зүйл. Эрүүгийн хуулийн 48.2-ын

“тоолно.” гэснийг “тоолох ба хорих ялыг тэнссэн бол хугацааг нь шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон үеэс эхлэн тоолно.” гэж, 50.3-ын “хорин дөрвөн” гэснийг “найман” гэж, 58.3, 58.4, 59.2-ын “хорин дөрвөн” гэснийг “найман” гэж, 68.3-ын “Болно.” гэснийг “Болох ба уг этгээдийн ялын хугацаанд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэсэн хугацааг оруулан тооцно.” гэж, 72 дугаар зүйлийн гарчгийн “татаж болохгүй” гэснийг “татах” гэж, 72.1.1-ийн “нэг жил” гэснийг “зургаан сар” гэж, 72.1.3-ын “хорин” гэснийг “арван таван” гэж, 72.1.4-ийн “гучин” гэснийг “хорин таван” гэж, 73.1-ийн “хэргийг шүүхээр хянан хэлэлцэх үед” гэснийг “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад” гэж, 76.1.1-ийн “нэг” гэснийг “гурван” гэж, 94.1-ийн “дөрвөн” гэснийг “таван” гэж, 103 дугаар зүйлийн гарчгийн “өвчнөө эмчлүүлэхээс зайлсхийх,” гэснийг “өвчин” гэж, 103.3-ын “103.2-г” гэснийг “103.1-д” гэж, 103.2-ын дугаарыг “103.1” гэж, 103.3-ын дугаарыг “103.2” гэж, 104.1-ийн “өгөөгүй” гэснийг “өгөөгүйгээс бусдад хүнд хор уршиг учирсан” гэж, 104.2-ын “хязгаарласан” гэснийг “хязгаарласны улмаас тухайн өвчтөнд гэм хор учирсан” гэж, 107 дугаар зүйлийн гарчгийн “насанд” гэснийг “биед” гэж, 107.1-ийн “насанд” гэснийг “биед”, “дөрвөн зуун” гэснийг “гурван зуун тавин” гэж, 107.2-ын “насанд” гэснийг “биед”, “тавин нэгээс” гэснийг “нэг зуун нэгээс”, “хоёр зуун тавин нэгээс дөрвөн зуун” гэснийг “гурван зуун тавин нэгээс таван зуун” гэж, 111.2-ын “хэвлэл, мэдээллийн хэрэгслээр” гэснийг “олон” гэж,

124.1-ийн “нэг зуун тавиас хоёр зуун тавь” гэснийг “нэг зуугаас хоёр зуу” гэж, 124.2-ын “хоёр зуугаас” гэснийг “хоёр зуун нэгээс”, “гурван жил” гэснийг “таван жил” гэж, 124.3-ын “гурваас дээш таван” гэснийг “таваас дээш арван” гэж, 126.2.5-ын дугаарыг 126.2.6 гэж, 129.1-ийн “таван зуун” гэснийг “гурван зуун тавин” гэж, 129.2-ын “хоёр зуун тавин нэгээс” гэснийг “гурван зуун тавин нэгээс” гэж, 132.1-ийн “хязгаарласан” гэснийг “хязгаарласны улмаас гэм хор учирсан” гэж, 135.1-ийн “хориос” гэснийг “таваас” гэж, 135.2-ын “далан нэгээс” гэснийг “тавин нэгээс” гэж, 137.1-ийн “хориос” гэснийг “таваас” гэж, 137.2-ын “далан нэгээс” гэснийг “тавин нэгээс” гэж, 138 дугаар зүйлийн гарчиг “Хөдөлмөрийн хууль тогтоомж” гэснийг “Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн журам” гэж, 139.1-ийн “гучин нэгээс” гэснийг “таваас” гэж, 144.3-ын “нэг зуугаас” гэснийг “нэг зуун нэгээс” гэж, 145.1-ийн “хулгайлсан” гэснийг “хулгайлсны улмаас бага бус хэмжээний хохирол учирсан” гэж, 145.2-ын “буюу бүлэглэж” гэснийг “бүлэглэж буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг,” гэж, 145.3-ын “урьдчилан үгсэж тохиролцсон” гэснийг “зохион байгуулалттай”, “найман” гэснийг “арван” гэж, 145.4-ийн “хэрэгт хоёр буюу түүнээс дээш удаа, эсхүл” гэснийг “хэргийг” гэж, 146.1-ийн “булаасан” гэснийг “булаасны улмаас бага бус хэмжээний хохирол учирсан” гэж, 146.2-ын “буюу бүлэглэж,” гэснийг “бүлэглэж буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг,” “далан таваас” гэснийг “тавин нэгээс” гэж, 146.3-ын “урьдчилан үгсэж тохиролцсон” гэснийг “зохион байгуулалттай”, “хоёр зуун далан таваас” гэснийг “хоёр зуун тавин нэгээс” гэж, 147.1-ийн “таваас дээш найман” гэснийг “гурваас дээш таван” гэж, 147.2-ын “наймас” гэснийг “таваас” гэж, 147.3-ын “хорин таван” гэснийг “хорин” гэж, 149.1-ийн “хоёр зуун тавин нэгээс гурван зуу” гэснийг “тавин нэгээс хоёр зуун тавь” гэж, 150.1-ийн “үрэгдүүлсэн, эсхүл албан тушаалын байдлаа урвуулж буюу эрх мэдлээ хэтрүүлж бусдын эд хөрөнгийг авсан” гэснийг “үрэгдүүлсний улмаас бага бус хэмжээний хохирол учирсан” гэж, 150.2-ын “их” гэснийг “үлэмж” гэж, 152.1-ийн “хорин таваас далан тав” гэснийг “таваас тавь” гэж, 154.2-ын “хоёр зуугаас хоёр зуун тавин” гэснийг “хоёр зуун тавин нэгээс таван зуун” гэж, 160.1-ийн “учирсан нь энэ хуулийн 155 дугаар зүйлд заасан гэмт хэргийн шинжгүй” гэснийг “учирсан” гэж, 161.1-ийн “их хэмжээтэйгээр эрхэлсэн” гэснийг “эрхэлж, үлэмж буюу их хэмжээний орлого олсон” гэж, 166.2-ын “онц их хэмжээний татвар ногдох” гэснийг “татвар ногдох онц их хэмжээний” гэж, 168.1-ийн

"нэг зуугаас хоёр зуун цаг" гэснийг "хоёр зуун тавин нэгээс таван зуун цаг" гэж, 171.1-ийн "удаа дараа буюу их хэмжээтэйгээр" гэснийг "худалдсанаас бусдын эрүүл мэндэд хохирол учирсан, эсхүл удаа дараа" гэж, 171.2-ын "их" гэснийг "үлэмж буюу их" гэж, 172.1-ийн "удаа дараа буюу их хэмжээтэйгээр" гэснийг "худалдсанаас бусдын эрүүл мэндэд хохирол учруулсан, эсхүл удаа дараа" гэж, 175.1-ийн "эд зүйл" гэснийг "эд зүйлийг бага бус хэмжээгээр", "нэг зуугаас" гэснийг "тавин нэгээс", "хоёр" гэснийг "нэг" гэж, 175.2-ын "эртний амьтан, ургамлын үндэс, үнэт өлдөр" гэснийг "эртний амьтны болон ургамлын өвөрмөц ховор үнэт олдвор", "тавиас" гэснийг "тавин нэгээс" гэж, 176 дугаар зүйлийн гэрчгийн "Мөнгөн тэмдэгт, үнэт цаасыг хуурамчаар үйлдэх, борлуулах" гэснийг "Мөнгөн тэмдэгт, үнэт цаас, онцгой албан татварын тэмдгийг хуурамчаар үйлдэх, ашиглах, борлуулах" гэж, 176.1-ийн "хэрэгслийг" гэснийг "хэрэгсэл, онцгой албан татварын тэмдгийг" гэж, 181.1-ийн "Олон нийтийг" гэснийг "Бусдыг", "бүдүүлгээр" гэснийг "ноцтой" гэж, 183.1-ийн "хасч" гэснийг "хасах буюу хасахгүйгээр", "хоёр зуун тавин нэгээс таван зуу" гэснийг "тавин нэгээс хоёр зуун тавь" гэж, 185.1-ийн "гучин нэгээс тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах" гэснийг "тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих" гэж, 185.2-ын "хоёроос таван" гэснийг "таваас дээш арван" гэж, 188.1-ийн "таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах" гэснийг "тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих" гэж, 193.1-ийн "хоёр зуугаас гурван зуун" гэснийг "хоёр зуун тавин нэгээс таван зуун" гэж, 197.1-ийн "тавин нэг" гэснийг "тавь" гэж, 215.1-ийн "тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах" гэснийг "тээврийн хэрэгсэл жолоодох", "жилийн" гэснийг "жил хүртэл" гэж, 215.2-ын "тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах" гэснийг "тээврийн хэрэгсэл жолоодох", "хоёр" гэснийг "нэг", "хоёроос таван" гэснийг "гурван" гэж, 215.3-ын "хоёр зуун тавин нэгээс таван зуу" гэснийг "нэг зуун тавин нэгээс

хоёр зуун тавь", "таваас дээш арван" гэснийг "гурваас дээш таван" гэж, 215.1, 215.2, 215.3 дахь хэсэгт заасан "хүний" гэснийг "бусдын" гэж, 218.1-ийн "тавин нэгээс дал" гэснийг "таваас тавь" гэж, 226.1-ийн "сүйтгэсний улмаас үлэмж хэмжээний хохирол учирсан" гэснийг "сүйтгэсэн" гэж, 227.1-ийн "авсан буюу авахыг завдсан" гэснийг "авсны улмаас бусдад бага бус хэмжээний хохирол учирсан" гэж, 230.2-ын "Энэ хэргийг үйлдэхдээ хүч хэрэглэж" гэснийг "Төрийн албан хаагчийг хуулиар хүлээсэн үүргээ гүйцэтгэж байхад нь болон олон нийтийн байцаагчийг хэв журам сахиулах үүргээ биелүүлж байхад нь хүч хэрэглэн эсэргүүцсэн", "таван зуун" гэснийг "гурван зуун тавин" гэж, 230.3-ын "хоёр зуугаас гурван зуун" гэснийг "гурван зуун тавин нэгээс таван зуун" гэж, 230.4-ийн "нэг зуугаас таван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх," гэснийг "хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавин нэгээс таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох," гэж, 230.2-ын дугаарыг "230.1." гэж, 230.3-ын дугаарыг "230.2." гэж, 230.4-ийн дугаарыг "230.3." гэж, 231 дүгээр зүйлийн "Тайлбар"-ын "шүүхийн шийдвэр гүйцэтгэгч," гэснийг "шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан," гэж, 232.1-ийн "алах," гэснийг "алахаар болон", "нэгээс гурван" гэснийг "гурваас дээш зургаан" гэж, 234.2-ын "нэг зуугаас хоёр зуун" гэснийг "хоёр зуун тавин нэгээс гурван зуун тавин" гэж, 237.1-ийн "нэг зуугаас хоёр зуун" гэснийг "хоёр зуун тавин нэгээс гурван зуун тавин" гэж, 237.2-ын "нэг зуугаас хоёр зуун" гэснийг "гурван зуун тавин нэгээс таван зуун" гэж, 242.1-ийн "тасалдсан" гэснийг "тасалдаж, бусдад их хэмжээний хохирол, хүнд хор уршиг учирсан", "хоёр" гэснийг "таван" гэж, 243.1-ийн "нэг зуугаас хоёр зуу" гэснийг "таваас тавь" гэж, 243.2-ын "хоёр зуун нэгээс" гэснийг "тавин нэгээс" гэж, 246.1-ийн "98" гэснийг "96", "тавин нэгээс ная" гэснийг "таваас тавь" гэж, 247.1-ийн "98" гэснийг "96" гэж, 251 дүгээр зүйлийн гэрчгийг "Эрүү шүүлт тулгах" гэж, 251.1-ийн "албадсан" гэснийг "албадан эрүү шүүлт тулгасан", "хасах буюу хасахгүйгээр" гэснийг "хасч" гэж, 251.2-ын "хасах буюу хасахгүйгээр" гэснийг "хасч" гэж, 253.2-ын "нэг зуугаас" гэснийг "нэг зуун нэгээс" гэж, 256.2-ын "их буюу онц их хэмжээний хохирол" гэснийг "энэ хэргийн улмаас хүнд хор уршиг" гэж, 257 дугаар зүйлийн гэрчгийн "Мөрдөн байцаалтын" гэснийг "Эрүүгийн хэргийн" гэж, 265.1-ийн "гурван зуун нэгээс дөрвөн зуу" гэснийг "таваас тавь", "гурваас

зургаан" гэснийг "нэгээс гурван" гэж, 271.1-ийн "хоёр зуун нэгээс гурван зуу" гэснийг "таваас тавь" гэж, 274.1-ийн "хуулийн тусгай ангид" гэснийг "бүлэгт" гэж, 281.1-ийн "их" гэснийг "үлэмж" гэж, 282.1-ийн "гэмтээсэн нь" гэснийг "гэмтээсний улмаас үлэмж хэмжээний хохирол учирсан нь" гэж, 288.2-ын "гурван" гэснийг "таван" гэж, 289.1-ийн "бага бус" гэснийг "үлэмж" гэж, 295.2-ын "таваас дээш долоон" гэснийг "гурваас дээш таван" гэж, 301 дүгээр зүйлийн Тайлбарын "төлөөлөгчийн газар" гэснийг "төлөөлөгчийн газрын ажилтнууд" гэж, 303.3-ын "гурваас таван" гэснийг "арван таваас дээш хорин" гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Эрүүгийн хуулийн 21.2-ын "181.2," гэснийг, 47.3-ын "баривчлах," гэснийг, 59.1-ийн "Гэхдээ ганданд ял эдлэх хугацаанд цагдан хоригдсон хугацааг оруулж тооцохгүй," гэснийг, 71.1-ийн "Энэ хуулийн тусгай ангийн 145.1 /Бусдын эд хөрөнгийг хулгайлах/-д зааснаас бусад" гэснийг, 73.1-ийн "шүүх" гэснийг, 110.1-ийн "эсхүл хэвлэл, мэдээллийн хэрэгслээр" гэснийг, 122.1-ийн "Насанд хүрсэн этгээд" гэснийг, 143.1-ийн "дахин" гэснийг дараахь "хүртэл" гэснийг, 145.4-ийн "зохион байгуулалттай бүлэг," гэснийг, 146.2-ын "бусдын амь насанд аюулгүй хүч хэрэглэж," , урьд

нь энэ хэрэгт шийтгүүлж байсан этгээд" гэснийг, 146.4-ийн "зохион байгуулалттай бүлэг," гэснийг, 172.1-ийн "эсхүл" гэснийг, 175.2-ын "хоёр зуун тавин нэгээс таван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх," гэснийг, 181.1-ийн "хоёр зуун тавин нэгээс гурван зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх" гэснийг, 196.2-ын "таван" гэснийг, 222.1-ийн "хөнгөн," гэснийг, 226.2-ын "эсхүл их буюу онц их хэмжээний хохирол учирсан" гэснийг, 234.2-ын "хоёроос" гэснийг, 242.1-ийн "буюу" гэснийг, 246.2-ын "нэгээс" гэснийг, 257.1-ийн "дахин" гэснийг дараахь "хүртэл" гэснийг, 258.1-ийн "эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих" гэснийг, 301 дүгээр зүйлийн "Тайлбар"-ын "гадаад улсын гадаад худалдааны байгууллагын ажилтнууд," гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл. Эрүүгийн хуулийн 163 дугаар зүйл, 167 дугаар зүйл, 239 дүгээр зүйл, 267 дугаар зүйл, 272 дугаар зүйл, 103 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 155 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 230 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 269 дүгээр зүйлийн "Тайлбар", 274 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 02 дугаар сарын 01-ний өдөр

Улаанбаатар хот

ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Захиргааны хариуцлагын тухай хуулийн 36 дугаар зүйлийн "бага хэмжээгээр" гэснийг дараа "хулгайлах, булаах, залилан мэхлэх, завшин үрэгдүүлэх замаар" гэж нэмсүгэй.

хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Эрүүгийн

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 02 дугаар сарын 01-ний өдөр

Улаанбаатар хот

ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 25 дугаар зүйлийн 8 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА ДЛҮНДЭЭЖАНЦАН**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 02 дугаар
сарын 01-ний өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.6-гийн "үйлдэл" гэсний дараа "эс үйлдэхүйг" гэж нэмсүгэй.

болон" гэснийг "хүндэвтэр," гэж, 343.1-ийн "магдлал гаргасан" гэснийг "анхан шатны" гэж, 344.1-ийн "давж заалдах" гэснийг "анхан" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 26 дугаар зүйлийн гарчиг "Хэрэг бүртгэлт явуулах байгууллага" гэснийг "Хэрэг бүртгэх эрх бүхий байгууллага" гэж, 26.2-ын "Авлигатай тэмцэх газрын хэрэг бүртгэгч" гэснийг "Авлигатай тэмцэх газар" гэж, 26.3-ын "Цагдаагийн байгууллагын хэрэг бүртгэгч" гэснийг "Цагдаагийн байгууллага нь" гэж, 208.1.1-ийн "24.1.4-д" гэснийг "24.1.6-д" гэж, 215.2.2-ын "тусгай харьяалалтай хүндэвтэр гэмт хэрэгт

3 дугаар зүйл. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 215.2.1-ийн "болон мөрдөн байцаалтын тусгай харьяалалтайгаас бусад хүндэвтэр" гэснийг хассугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 02 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

ДҮРЭМ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагын дүрмийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон

баталсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны 02 дугаар
сарын 06-ны өдөр

Улаанбаатар
хот

ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар, Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газар хооронд 2007 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Вашингтон хотноо байгуулсан Үй олноор хөнөөх зэвсэг, түүнийг зөөвөрлөх систем, холбогдох бусад материалыг далайд дэлгэрүүлэхийг хориглох

талаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 265958
Индекс 14003

☎ 329487

Хэвлэлийн хуудас 3.5